



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1514

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, мөн зүйлийн 14.4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/50 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээг дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ (Р.Амартүвшин)-т үүрэг болгосугай.

2. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 1,217,477,310.0 (нэг тэрбум хоёр зуур арван долоон сая дөрвөн зуун далан долоон мянга гурван зуун арав) төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “186”-д батлагдсан “Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө боловсруулах (Улаанбаатар хот)” зардлаас холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Л.Эрдэнэбадрах)-т, 1-3 дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Б.Одбаяр)-т, 4 дэх заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг зохих журмын дагуу бүртгэлжүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725022476

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 17-ны өдрийн
АХСН дүгээр захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2025 ОНЫ
ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамжийг Нарны замтай 3 байршилд холбох /Натур төв орчмын/ ажлын зураг төсөл	2025	2025	217.2	217.2
2	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо Нарантуул худалдааны төвийн хойноос Өгөөмөр хотхоны үерийн суваг хүртэлх авто зам, Нарны замтай холбогдох холбоос замын ажлын зураг төсөл	2025	2025	286.1	286.1
3	Хан-Уул дүүргийн 17-р хороо, Их Монгол Улсын гудамжнаас Зайсангийн гудамж /Фредрик Шопены гудамж/ хүртэлх авто замын ангилал, зэрэглэл дээшлүүлэх ажлын зураг төсөл	2025	2025	509.9	509.9
4	Бурхны шашинтны төв, Гандантэгчэнлин хийдийн тохижилтын эскиз, төв талбайн ажлын зураг, инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл	2025	2025	204.3	204.3
Нийт дүн				1,217.5	1,217.5



نقد و بررسی هر یک از سبک‌های معماری و هنر
در دوره صفویه

میتنسونیتون

فصل پنجم

۱۵۹

پیشہ کا نام

و

مختصراً بمقتضى هذا العدد
من كتابه والحقائق

[illegible][illegible][illegible]

